

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ ЦЭРЭНБААТАРЫН АЛТАНЦАЦРАЛЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн түвшин						
	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
	1	2	3	4	5	6	7
Нэг. “Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын Их хурал, Засгийн газар, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах” зорилтын хүрээнд”							
1.	Арга хэмжээ 1.1 Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0	50%	Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хуралдаанд танилцуулж, 23 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа. Төлөвлөгөөний дагуу Салбар зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг ханган, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг тухай бүр боловсруулан хуралдааныг дэгийн дагуу хуралдуулан, хурлаас гарсан шийдвэрийг 3 хоногийн дотор эцэслэн албажуулан ажиллалаа. Энэ оны хагас жилийн байдлаар Салбар зөвлөлийн хурлыг 4 удаа хуралдуулж дараах асуудлуудыг хэлэлцүүлж шийдвэр гаргуулсан байна. Үүнд:Төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зохион байгуулах ажлын хэсэг томилох тухай, Харьяа байгууллагуудын зарим удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтын тайлан, Албан тушаалд нэр дэвшүүлж, санал болгох тухай, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн	2025.01.01-2025.06.31	100

						хамгааллын яам болон харьяа байгууллагуудын төрийн захиргааны албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв шинээр болон ахиулан олгох санал гаргах тухай, Төрийн албаны тэргүүний ажилтан шагналд уламжлах тухай зэрэг асуудлыг хэлэлцэн, хэлэлцсэн асуудлаар 65 тогтоол гаргасан байна. Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төрийн албаны шинэтгэл болон сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн сумдын төрийн албан хаагчдад сургалт, мэдээлэл өгөх, соён гэгээрүүлэх, хяналт шалгалт хийх, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах ажлаар орон нутагт Төрийн албаны зөвлөлийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Хөдөлмөрийн бодлогын газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж хариуцсан ахлах шинжээч П.Хишигжаргал, Салбарын хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын бодлого төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн М.Ууганбаатар, Хөдөлмөрийн бодлогын газрын Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний хэлтсийн шинжээч О.Мягмарсүрэн нарыг оролцуулав.	2025.01.01-2025.06.31	100
2.	Арга хэмжээ 1.2. Яамны дэргэдэх албаны зөвлөлийн хэмжээний тушаалын шалгаруулалт явуулах захиалгыг хүлээн авах, хянах, зарлуулах, шалгалтын комисс байгуулах, зохион	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0	50%	Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлөөс салбарын хэмжээний төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх, төрийн үйлчилгээний удирдах албаны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан			

	байгуулах, нэр дэвшүүлэх, томилох						
3	Арга хэмжээ №1.3. Төрийн албаны тухай хуулийн дагуу тусгай шаардлага хангасан төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох санал гаргах, зэрэг дэв олгуулах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0	50%	Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-д заасан болзол хангасан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон харьяа байгууллагуудын Ахлах болон Дэс түшмэлийн зэрэгт хамаарах албан хаагчдын албан тушаалын зэрэг дэв ахиулах болон шинээр олгох асуудлыг Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн 20 дугаар тогтоолоор 144 албан хаагчийн зэрэг дэвийн асуудлыг шийдвэрлэсэн. Журмын дагуу салбарын хэмжээнд Эрхэлсэн түшмэлийн зэрэгт хамаарах 10 албан хаагчдын албан тушаалын зэрэг дэв ахиулах болон шинээр олгох асуудлыг Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ээлжит хуралдаанаар хэлэлцэн, 58 дугаар тогтоол гарган санал авахаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.	2025.01.01-2025.06.31	100
4.	Арга хэмжээ №1.4. Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх болзол хангасан албан хаагчдын материал	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0	50%	Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх болзол хангасан албан хаагчдын материалыг харьяа агентлагуудаас хүлээн авч хянан, Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын	2025.01.01-2025.06.31	100

	хүлээн авах, хянах, Тангараг өргөх ёслолын ажиллагаа зохион байгуулах				ямны дэргэдэх салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн 59 дүгээр тогтоол гарган, Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх заалт, Ерөнхийлөгчийн 2024 оны 84 дүгээр зарлигаар баталсан "Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам"-д заасны дагуу 26 албан хаагчийг Төрийн албаны 30 жилийн ойн босгон дээр Төрийн албаны тангараг өргүүлэх ёслолын ажиллагааг 05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан.		
5.	Арга хэмжээ №1.5. Төрийн албаны тусгай шалгалтын Ярилцлагын хэсэгт технологийг нэвтрүүлэх ажлыг эхлэх	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0	50%	Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлөөс салбарын хэмжээний төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх, төрийн үйлчилгээний удирдах албаны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын дагуу зохион байгуулан ажиллаж байна. Төрийн албаны тусгай шалгалтын Ярилцлагын хэсэгт техник технологийг нэвтрүүлэх зорилт тавьж энэ ажлын хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 7 давхарт "Ярилцлагын өрөө" шинээр гарган засварлаж, шалгалтад ашиглах ухаалаг дэлгэц, зөөврийн 5 ширхэг компьютер, 12 ширхэг сандлын захиалгыг 2025 оны яамны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулан, тоног төхөөрөмж, эд хогшлын техникийн тодорхойлолтыг гарган, Цахимжилт, их өгөгдлийн бодлогын газарт хүргүүлсэн.	2025.01.01-2025.06.31	100

Хоёр. Монгол Улсын Их хурал, Засгийн газрын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллах зорилтын хүрээнд

1.	Арга хэмжээ Салбарын зарим удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулан мөрдүүлэх	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0	50%	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 3.9-т заасны дагуу аймаг, дүүргүүдийн Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгааллын гэээр хэлстийн удирдах болон гүйцэтгэх 12 албан тушаалын тодорхойлолт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 30 албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэргэдэх салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэн Төрийн албаны зөвлөлөөс батлах зөвшөөрөл авахаар хүргүүлсэн. Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан сум, хороо бүрд ажиллах Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны албан тушаалын тодорхойлолтод Салбар зөвлөлийн 22 дугаар тогтоолоор батлах зөвшөөрлийг олгов. Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяа БНСУ дахь хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дарга, Хараагүй хүний хөдөлмөр, сургалт, хөгжлийн төвийн дарга, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн даргын албан тушаалын тодорхойлолтыг шинээр болон шинэчлэн боловсруулж Төрийн албаны зөвлөлөөс санал авч, Гэр бүл, хөдөлмөр,	2025.01.01-2025.06.31	100
----	--	---	---	-----	---	-----------------------	-----

2	Арга хэмжээ №2.2. Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын үйл ажиллагааны бүтцийн өөрчлөлтийн байгууллагуудын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлуулах ажилд дэмжлэг үзүүлэх	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0	70%	нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлуулсан. Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлуулах ажилд дэмжлэг үзүүлэн ажиллаж, энэ оны хагас жилийн байдлаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны Б/74 дүгээр тушаалаар батлуулж, Олон Улсын хүүхдийн Найрамдал цогцолбор, Ахмад настны үндэсний төв, БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих төв, Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн дүрэм, бүтцийн схем, албан тушаалын жагсаалтыг Сайдын тушаалаар тус тус батлуулсан. Түүнчлэн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн дэргэд ажиллаж байсан Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газар нь Засгийн газрын 2025 оны 196 дугаар тогтоолоор татан буугдсантай холбоотойгоор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын орон тооны хязгаарт өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын	2025.01.01-2025.06.31	100
---	---	---	---	-----	--	-----------------------	-----

					төслийг бэлтгэн яамдаас санал авч, ХХҮЕГ-ын орон тооны хязгаарт өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын 2025 оны 08 дугаар тогтоолыг батлуулсан. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын орон тооны хязгаарт өөрчлөлт оруулах асуудлын талаарх материалыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн.			
3.	Арга хэмжээ №2.3. Харьяа байгууллагуудын төсвийн ерөнхийлөн захирагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж, албажуулах ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлийн үнэлгээ хийлгүүлэх, үнэлгээний мөрөөр урамшуулах, хариуцлага тооцох ажлыг зохион байгуулах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0	50%	Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа агентлагууд, байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж, яамны бодлоготой уялдуулах зорилгоор 9 газрын дарга, Төрийн нарийн бичгийн даргад танилцуулан санал авч, агентлаг, байгууллагуудын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг сайдаар албажуулах ажлыг зохион байгуулсан.	2025.01.01-2025.06.31	100	
4.	Арга хэмжээ №2.4. Төрийн албаны өдрийг угтан Монгол Улсын Их Хурлын даргын ивээл дор зохион байгуулах Төрийн албаны Үндэсний хаагчдын Үндэсний чуулганы зохион байгуулалтад оролцох	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0	100%	Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ойн хүрээнд Төрийн албаны шинэтгэл болон сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" бүсийн зөвлөгөөнд Төрийн нарийн бичгийн дарга, Салбар зөвлөлийн дарга Л.Мөнхзул, Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Салбар зөвлөлийн гишүүн Б.Алимаа, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Салбар	2025.01.01-2025.06.31	100	

					зөвлөлийн гишүүн Д.Ренчиндорж, Хөдөлмөрийн бодлогын газрын Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний хэлтсийн дарга Б.Нарангарав нар үндсэн илтгэгчээр оролцсон.				
4.	Арга хэмжээ №2.5. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны болон сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын Хүний нөөцийн ажилтнуудын туршлага харилцан солилцох өдөрлөг зохион байгуулах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0	50%	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын Хүний нөөцийн албан хаагчдад Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системийн шинэ модуль, дэд системүүдийг танилцуулах, түүнийг хэрэглээнд нэвтрүүлэх, систем хэрэглэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, харьяа байгууллагууд, Нийгмийн даатгалын ерөнхий газар, харьяа байгууллагууд, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, харьяа байгууллагууд, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, харьяа байгууллагууд, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын Захиргааны нэгжийн дарга нар, Хүний нөөцийн албан хаагчид 78 ажилтан; цахимаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын орон нутаг дахь байгууллагуудын Газрын дарга, Захиргааны нэгжийн дарга, Хүний нөөцийн албан хаагчид 202, нийт 280 орчим албан хаагч оролцсон.	2025.01.01-2025.06.31	100		

					хяналт, тушаал шийдвэр, мэдээллийг бүртгэх хүний нөөцийн нэгдсэн систем юм. Энэхүү системийг ашигласнаар байгууллагын хүний нөөцтэй холбоотой бүхий л үйл ажиллагааг автоматжуулж, цаасгүй төрийн албыг бий болгож, цаг хугацаа хэмнэж, ухаалаг шийдвэрүүдийг гаргахад ач холбогдолтой юм.	
--	--	--	--	--	--	--

Хоёр. Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
1.	Арга хэмжээ 3.1. Салбарын удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0	50%	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын бодлогын шинэчлэл, 2025 онд баримтлах салбарын стратегийн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгасан асуудлууд, салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаар санал солилцох, зөвлөлдөх, орон нутгийн хэмжээнд цаашид анхаарах асуудлаар арга зүйн удирдлагаар хангахад чиглэгдсэн Салбарын Удирдах ажилтны зөвлөгөөнийг 2025 оны 3 дугаар сард амжилттай зохион байгуулсан.	2025.01.01- 2025.06.31	100
2.	Арга хэмжээ 3.2. Хараагүй хүний хөдөлмөр сургалт хөгжлийн төвд шалгалтын ажлын хэсэгт ажиллах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0	100%	Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/10 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, "Хараагүй хүний хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв" УТҮГ-т батлагдсан удирдамжийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд иргэний гомдлын дагуу хяналт шалгалт хийх, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэсэн.	2025.01.01- 2025.06.31	100

--	--	--	--	--	--	--	--	--

Гурав.Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Биелэлт ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Хариуцсан ажлын зохилт, чиглэлээр байгуулах сургалт, семинар, хөтөлбөрт хамрагдах	Суралцсан кредит цаг	-	Хариуцсан ажлын чиглэлээр шинэ мэдээлэл, ойлголттой болсон байна.	-ТАЗ-өөс зохион байгуулсан Салбар зөвлөлийг арга зүйгээр хангах цаг үеийн сургалт, семинарт оролцсон. -Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 14 хоног тутамд зохион байгуулсан Мэдээллийн цаг хөтөлбөрт бүрэн хамрагдсан.	2025.01.01- 2025.06.31	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

Салбарын хүний нөөц
хариуцсан ахлах шинжээч
(Албан тушаал)

Ц.Алтанцацрал

2025.06.05

(Нэр, гарын үсэг)

(O₂H₂O)

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН
АХЛАХ ШИНЖЭЭЧ АХЛАХ ШИНЖЭЭЧ ЦЭРЭНБААТАРЫН АЛТАНЦАЦРАЛЫН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ
ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)**

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Нэгжийн нэр: Төрийн захиргааны удирдлагын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
<i>Зорилт 1. "Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын Их хурал, Засгийн газар, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах" зорилтын хүрээнд"</i>					
1.	Арга хэмжээ 1.1 Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах	60	10	70	70
2.	Арга хэмжээ 1.2. Яамны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлийн эрх хэмжээний албан тушаалын сонгон шалгаруулалт явуулах захиалгыг хүлээн авах, хянах, зарлуулах, шалгалтын комисс байгуулах, зохион байгуулах, нэр дэвшүүлэх, томилох	60	10	70	70
3.	Арга хэмжээ №1.3. Төрийн албаны тухай хуулийн дагуу тусгай шаардлага хангасан төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох санал гаргах, зэрэг дэв олгуулах	60	10	70	70
4	Арга хэмжээ №1.4. Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх болзол хангасан албан хаагчдын материал хүлээн авах, хянах, Тангараг өргөх ёслолын ажиллагаа зохион байгуулах	60	10	70	70
5	Арга хэмжээ №1.5. Төрийн албаны тусгай шалгалтын Ярилцлагын хэсэгт техник технологийг нэвтрүүлэх ажлыг эхлэх	40	5	45	45
<i>Хоёр. Монгол Улсын Их хурал, Засгийн газрын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллах зорилтын хүрээнд</i>					

1.	Арга хэмжээ №2.1. Салбарын зарим удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулан мөрдүүлэх	50	5	55	55
2.	Арга хэмжээ №2.2. Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлуулах ажилд дэмжлэг үзүүлэх	60	10	70	70
3.	Арга хэмжээ №2.3. Харьяа байгууллагуудын төсвийн ерөнхийлөн захирагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж, албажуулах ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлийн үнэлгээ хийлгүүлэх, үнэлгээний мөрөөр урамшуулах, хариуцлага тооцох ажлыг зохион байгуулах	60	10	70	70
4.	Арга хэмжээ №2.4. Төрийн албаны өдрийг угтан Монгол Улсын Их Хурлын даргын ивээл дор зохион байгуулах Төрийн албаны хаагчдын Үндэсний чуулганы зохион байгуулалтад оролцох	50	5	55	55
5.	Арга хэмжээ №2.5. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны болон сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын Хүний нөөцийн ажилтнуудын туршлага харилцан солилцох өдөрлөг зохион байгуулах	50	5	55	55
3. Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт					
1.	Арга хэмжээ 3.1. Салбарын удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулах	60	10	70	70
2.	Арга хэмжээ 3.2. Хараагүй хүний хөдөлмөр сургалт хөгжлийн төвд шалгалтын ажлын хэсэгт ажиллах	60	10	70	70
Дундаж оноо:				64,1	

2.Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1. Хариуцсан ажлын чиглэлээр яам болон бусад байгууллагаас зохион байгуулах сургалт, семинар, хөтөлбөрт хамрагдах	90%	13	13
Дундаж оноо			13	13

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	7
2.	Дүн шинжилгээ хийх	7	7
3.	Асуудал шийдвэрлэх	7	7
4.	Хариуцлагатай байдал	7	7
5.	Ажлын цаг ашиглалт	7	7
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.	7	7
7.	Мэргэжлийн ур чадвар 2.	7	7
8.	Мэргэжлийн ур чадвар 3.	7	7
Дундаж оноо		7	7

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8


5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	(70 хүртэлх оноо) 64.1
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 хүртэлх оноо) 13
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(7 хүртэлх оноо) 7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо) 8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		92.1

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Төрийн захиргааны
удирдлагын газрын даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

/Б.Түвшинжаргал /
(нэгжийн удирдлагын нэр)
2025.06...13.

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Салбарын хүний нөөц
хариуцсан ахлах шинжээч
(албан тушаал)

Төрийн жинхэнэ албан хаагч:

.....
(гарын үсэг)

Ц.Алтанцацрал
(албан хаагчийн нэр)
2025.06.05

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

.....
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

Б.Мунхмуурал
(албан хаагчийн нэр)
2025.06.20...

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Яамны хүний нөөцийн асуудал
хариуцсан шинжээч
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

Б.Баянжаргал
(албан хаагчийн нэр)
2025.06.20...

Үнэлгээг баталгаажуулсан:

Төрийн нарийн бичгийн дарга
(албан тушаал)

Төсвийн шууд захирагч

.....
(гарын үсэг)

Л.Мөнхзул
(байгууллагын удирдлагын нэр)
2025.06.20

